1.8. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1. Гэмт хэрэгт холбогдсон нийт хүн:

- 497 хүн шалгагдсан,
- өмнөх оныхоос 16.9 хувиар өссөн,
- шалгагдсан нийт хүний 28.0 хувийг эмэгтэй хүн, 3.0 хувийг хүүхэд эзэлж байна.

2.2. Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



2.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

3.1. Гэмт хэргийн улмаас:

- 369 иргэн, 25 аж ахуйн нэгж, байгууллага *хохирсон,*
- үүнээс 9 хүн нас барсан,
- 106 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүн 47.1 хувиар буурч,
- гэмтсэн хүн 5.0 хувиар өссөн.

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол:



§6.9. Төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг	277	276	-1	-0.4
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	1.3	1.1	0.2	

1.1. Гэмт хэргийн ангиллаар:



1.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:

- өмнөх оныхоос хөнгөн ангиллын гэмт хэрэг 20 хэргээр буюу 15.5 хувиар,
- онд хүнд ангиллын гэмт хэрэг 6 хэргээр буюу 2.2 дахин тус тус өссөн,
- хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 25 хэргээр буюу 19.8,
- хүнд ангиллын гэмт хэрэг 2 хэргээр буюу 11.8 хувиар тус тус буурсан.

1.3. Төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

- 0.4 хувийг хүчиндэх,
- 0.4 хувийг танхайрах,
- 6.5 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
- 11.6 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх,
- 29.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 30.4 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 21.0 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг:

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг:

- 89 нь 06-14 цагт,
- 96 нь 14-19 цагт,
- 35 нь 19-22 цагт,
- 56 нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

1.6. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

- Орчин ахуйн хөгжлийн 5,
- Спортын 6,
- Байгаль орчны 7,
- Соёл урлагийн 9,
- Сүм, хийд 16,
- Эрүүл мэндийн 44,
- Боловсролын 80,
- Бусад газарт 109 бүртгэгдсэн байна.

1.7. Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 57.6 хувь нь нийслэл хотод,
- 38.4 хувь нь аймгуудад бүртгэгдсэн.

1.8. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1. Гэмт хэрэгт холбогдсон нийт хүн:

- 240 хүн шалгагдсан,
- өмнөх оныхоос 3.2 хувиар буурсан,
- шалгагдсан нийт хүний 36.7 хувийг эмэгтэй хүн, 7.5 хувийг хүүхэд эзэлж байна.

2.2. Төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



2.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

3.1. Гэмт хэргийн улмаас:

- 264 иргэн, 3 аж ахуйн нэгж, байгууллага хохирсон,
- үүнээс 10 хүн нас барсан,
- 84 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүн 16.7 хувиар буурч,
- гэмтсэн хүн 13.5 хувиар өссөн.

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол:



§6.10. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг	3764	5363	1599	+42.5
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	17.0	21.1	- 4.1	

1.1. Гэмт хэргийн ангиллаар:



1.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:

- өмнөх оныхоос хөнгөн ангиллын гэмт хэрэг 879 хэргээр буюу 54.3 хувиар,
- хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 644 хэргээр буюу 41.9 хувиар,
- хүнд ангиллын гэмт хэрэг 79 хэргээр буюу 14.3 хувиар тус тус өссөн,
- онц хүнд ангиллын гэмт хэрэг 3 хэргээр буюу 5.7 хувиар буурсан.

1.3. Гудамж талбайд үйлдэгдсэн хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

- 0.7 хувийг хүнийг санаатай алах,
- 0.8 хувийг хүчиндэх,
- 1.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 2.5 хувийг залилан мэхлэх,
- 2.8 хувийг булаах,
- 8.3 хувийг дээрэмдэх,
- 15.5 хувийг танхайрах,
- 18.2 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 38.4 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 11.8 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг:

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг:

- 715 нь 06-14 цагт,
- 1206 нь 14-19 цагт,
- 1148 нь 19-22 цагт,
- 2294 нь 22-06 цагт тус тус

үйлдэгдсэн байна.

1.6. Гудамж талбайд гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

- Гэр хорооллын гудамжинд 2230,
- Орон сууцны хорооллын гудамжинд 1529,
- Ил зогсоолд 444,
- Автобусны буудалд 319,
- Цэцэрлэгт хүрээлэнд 51,
- Тоглоомын талбайд 45,
- Төмөр замд 7,
- Бусад газарт 738 байна.

1.7. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 73,9 хувь нь нийслэл хотод,
- 1399 буюу 25.9 хувь нь аймгуудад бүртгэгдсэн.

1.8. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1. Гэмт хэрэгт холбогдсон нийт хүн:

- 4937 хүн шалгагдсан нь өмнөх оныхоос 45.5 хувиар өссөн,

-шалгагдсан нийт хүний 9.9 хувийг эмэгтэй, 8.0 хувийг насанд хүрээгүй хүн эзэлж байна.

2.2. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



2.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

3.1 Гэмт хэргийн улмаас:

- 5415 иргэн хохирсоноос 1544 нь эмэгтэй хүн, 485 нь 7-18 хүртэлх насны хүн байна.
- хохирсон иргэдээс 94 хүн нас барсан,
- 2827 хүн гэмтсэн.

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол /сая төг-өөр/:



§7. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ

§7.1. Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1. *Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:*

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Ажилгүй хүн үйлдсэн гэмт хэрэг	9380	10176	796	+ 8.5
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	42.5	40.1	- 2.4	

1.1. Гэмт хэргийн ангиллаар:



1.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:

- өмнөх оныхоос хөнгөн ангиллын гэмт хэрэг 784 хэргээр буюу 19.3,
- хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 162 хэргээр буюу 3.9 тус тус өссөн,
- хүнд ангиллын гэмт хэрэг 103 хэргээр буюу 11.6 хувиар,
- онц хүнд ангиллын гэмт хэрэг 47 хэргээр буюу 18.9 хувиар тус тус буурсан.

1.3. Ажилгүй хүмүүсээс үйлдсэн хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

- 0.8 хувийг булаах,
- 1.0 хувийг хүнийг санаатай алах,
- 1.2 хувийг завших, үрэгдүүлэх,
- 1.6 хувийг хүчиндэх,
- 2.5 хувийг дээрэмдэх,
- 5.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 5.6 хувийг залилан мэхлэх,
- 8.1 хувийг танхайрах,
- 29.1 хувийг хулгайлах,
- 31.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах
- 12.9 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.4. Гэмт хэрэг үйлдсэн гараг:

1.5. Гэмт хэрэг үйлдсэн цаг:

- 1747 нь 06-14 цагт,
- 2593 нь 14-19 цагт,
- 1947 нь 19-22 цагт,
- 3889 нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

1.6. Гэмт хэрэг үйлдсэн газар:

- Гэр, орон сууцанд 3201,
- Гудамж талбай 2303,
- Олон нийтийн газарт 1385 ,
- Нийтийн тээвэрт 104,
- Төрийн байгууллага 129,
- Төрийн бус байгууллага 69,
- Аж ахуй нэгжид 611,
- Авто зам 854,
- Бусад газар 1520 тус тус бүртгэгдсэн байна.

1.7. Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 59.9 хувь нь нийслэл хотод,
- 39.4 хувь нь аймгуудад бүртгэгдсэн.

1.8. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1. Гэмт хэрэгт холбогдсон нийт хүн:

- 11309 хүн, үүнээс 1576 эмэгтэй шалгагдсан,
- өмнөх оныхоос 8.8 хувиар өссөн байна.

2.2. Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

3.1. Гэмт хэргийн улмаас:

- 10449 иргэн, 62 аж ахуйн нэгж, байгууллага хохирсон,
- үүнээс 266 хүн нас барсан,
- 4437 хүн гэмтсэн,

өмнөх оныхоос нас барсан хүн 71.9 хувиар, гэмтсэн хүн 54.7 хувиар тус тус буурсан.

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол / сая төг- өөр /:



§7.2. Эмэгтэй хүн үйлдсэн гэмт Хэргийн нөхцөл байдал

1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг	2761	3160	399	+14.5
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	12.5	12.5	0.0	

1.1. Гэмт хэргийн ангиллаар:



1.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:

- өмнөх оныхоос хөнгөн ангиллын гэмт хэрэг 403 хэргээр буюу 27.0,
- хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 31 хэргээр буюу 3.1 хувиар тус тус өсөж,
- хүнд ангиллын гэмт хэрэг 16 хэргээр буюу 9.0,
- онц хүнд ангиллын гэмт хэрэг 19 хэргээр буюу 20.2 хувиар тус тус буурсан.

1.3. Эмэгтэй хүн үйлдсэн хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

- 0.1 хувийг хүчиндэх,
- 0.5 хувийг дээрэмдэх,
- 0.9 хувийг хүнийг санаатай алах,
- 4.0 хувийг танхайрах,
- 4.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 4.9 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
- 13.5 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх,
- 16.9 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 33.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 21.5 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.4. Гэмт хэрэг үйлдсэн гараг:

1.5. Гэмт хэрэг үйлдсэн цаг:

- 799 нь 06-14 цагт,
- 1040 нь 14-19 цагт,
- 500 нь 19-22 цагт,
- 821 нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

1.6. Гэмт хэрэг үйлдсэн газар:

- Гэр, орон сууцанд 790,
- Олон нийтийн газарт 700,
- Гудамж талбайд 482,
- Аж ахуй нэгжид 414,
- Авто замд 200,
- Төрийн байгууллагад 144,
- Төрийн бус байгууллагад 83,
- Нийтийн тээвэрт 24,
- Бусад газарт 323 бүртгэгдсэн байна.

1.7. Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 68.2 хувь нь нийслэл хотод,
- 29.9 хувь нь аймгуудад бүртгэгдсэн.

1.8. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.*1. Гэмт хэрэгт холбогдсон нийт хүн:*

- 3137 хүн шалгагдсан,
- өмнөх оныхоос 17.6 хувиар өссөн,
- шалгагдсан эмэгтэй хүний 3.9 хувийг насанд хүрээгүй хүн эзэлж байна.

2.*2. Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:*



2.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

3.1. Гэмт хэргийн улмаас:

- 9838 иргэн хохирсон,
- үүнээс 239 хүн нас барсан,
- 3583 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүн 3.5 хувиар,
- гэмтсэн хүн 17.8 хувиар тус тус өссөн.

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол /сая төг-өөр/:

§7.3. Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг	1076	1029	47	-4.4
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	4.2	4.1	- 0.1	

1.1. Гэмт хэргийн ангиллаар:



1.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:

- өмнөх оныхоос хөнгөн ангиллын гэмт хэрэг 7 хэргээр буюу 2.1,
- хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 7 хэргээр буюу 1.3,
- хүнд ангиллын гэмт хэрэг 17 хэргээр буюу 11.0,
- онц хүнд ангиллын гэмт хэрэг 16 хэргээр буюу 53.3 хувиар тус тус буурсан.

1.3. НХХ-ээс үйлдэгдсэн хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

- 0.1 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
- 0.7 хувийг хүнийг санаатай алах,
- 1.2 хувийг залилан мэхлэх,
- 1.6 хувийг ТХХАБАЖЗөрчих,
- 2.4 хувийг булаах,
- 2.7 хувийг хүчиндэх,
- 8.0 хувийг танхайрах,
- 9.7 хувийг дээрэмдэх,
- 21.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 46.6 хувийг хулгайлах,
- 5.4 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг:

1.5. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг:

- 159 нь 06-14 цагт,
- 295 нь 14-19 цагт,
- 175 нь 19-22 цагт,
- 400 нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна.

1.6. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

- Нийтийн тээвэрт 4,
- Төрийн байгууллагад 14,
- Авто замд 21,
- Төрийн бус байгууллагад 18,
- Аж ахуй нэгжид 57,
- Олон нийтийн газарт 198,
- Гэр, орон сууцанд 295,
- Гудамж талбайд 338,
- Бусад газарт 84 бүртгэгдсэн байна.

1.7. НХХ-ээс үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 53.4 хувь нь нийслэл хотод,
- 46.5 хувь нь аймгуудад бүртгэгдсэн.

1.8. Гэмт хэргийн гаралт өмнөх оныхоос буурсан, өссөн үзүүлэлт нутаг дэвсгэрээр:





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн:

- 605 хүн шалгагдсан,
- өмнөх оныхоос 25.6 хувиар буурсан,
- шалгагдсан нийт хүний 7.6 хувийг эмэгтэй эзэлж байна.

2.2. НХХ-ээс үйлдсэн гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



2.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

3.1. Гэмт хэргийн улмаас:

- 443 иргэн, 1 аж ахуйн нэгж, байгууллага хохирсон,
- үүнээс 7 хүн нас барсан,
- 169 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүн 53.3 хувиар,
- гэмтсэн хүн 29.0 хувиар тус тус буурсан.

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол /сая төг-өөр/:



§7.4. Гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэдийн нөхцөл байдал:

1. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэд:

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Гэмт хэрэг холбогдсон гадаадын иргэн	89	79	10	-11.2

1.1. Гадаадын иргэдээс үйлдэгдсэн хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

- 1.3 хувийг танхайрах,
- 2.6 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
- 4.0 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 8.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 13.3 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх,
- 34.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 36.2 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.2. Үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

- 66.6 хувь нь нийслэл хотод,
- 33.3 хувь нь аймгуудад бүртгэгдсэн.

1.3. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн иргэншил:

- 51.9 хувийг БНХАУ-ын,
- 15.2 хувийг ОХУ-ын,
- 10.2 хувийг БНСУ-ын,
- 3.8 хувийг тус бүр Франц, Вьетнам улсын,
- 2.5 хувийг тус бүр Бангладеш, Австрали, Япон улсын,
- 7.6 хувийг бусад улсын иргэд эзэлж байна.

1.4. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн насны ангиллаар:



1.5. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн нийгмийн байдал:

2. Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэд:

№	Үзүүлэлт	2012	2013	Өсөлт, бууралт	
				тоогоор	хувиар
1	Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэн	121	126	5	+4.1

2.1. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэний иргэншил:

- 38.8 хувийг БНХАУ-ын,
- 16.6 хувийг ОХУ-ын,
- 9.5 хувийг БНСУ-ын,
- 4.7 хувийг АНУ-ын,
- 3.2 хувийг Япон улсын,
- 2.4 хувийг тус бүр Австрали, Герман улсын,
- 22.4 хувийг бусад улсын иргэд эзэлж байна.

2.2. Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэдийн насны ангиллаар:



2.3. Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэдийн нийгмийн байдал:



§7.5. Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

1.1. Гэмт хэрэг үйлдсэн урьд нь ял шийтгэгдсэн хүн:

- 2013 онд урьд нь ял шийтгэгдсэн 909 хүн гэмт хэрэгт холбогдсон,
- өмнөх оныхоос 9-өөр буюу 1.0 хувиар өссөн,
- нийт гэмт хэрэгт холбогдсон хүмүүст эзлэх хувийн жин 4.1 хувь байна.

1.2. Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс:

- 0.7 хувь нь булаах,
- 1.4 хувь нь хүнийг санаатай алах,
- 1.8 хувь нь хүчиндэх,
- 3.4 хувь нь дээрэмдэх,
- 4.3 хувь нь залилан мэхлэх,
- 9.2 хувь нь танхайрах,
- 20.6 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 51.3 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 7.3 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.

1.3. Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсийн гэмт хэрэгт холбогдсон газар нутаг дэвсгэрээр:

1.4. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:

1.5. Дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг боловсролоор нь авч үзвэл:

- 2.7 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд,
- 5.1 хувь нь дээд,
- 8.4 хувь нь ямар нэг боловсролгүй,
- 19.1 хувь нь бага,
- 31.7 хувь нь суурь,
- 32.9 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна.

Эдгээр хүмүүсийн 17 буюу 1.9 хувь нь насанд хүрээгүй, 45 буюу 4.9 хувь нь эмэгтэй хүн, 298 нь буюу 32.8 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.

Захиргааны хяналтад байгаа хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

1.1. Гэмт хэрэг үйлдсэн захиргааны хяналтанд байсан хүн:

- 2013 онд захиргааны хяналтанд байсан 117 хүн гэмт хэрэгт холбогдсон,
- өмнөх оныхоос 46-аар буюу 64.9 хувиар өссөн.

1.2. Захиргааны хяналтанд байсан хүмүүсээс:

- 1.7 хувь нь хүнийг санаатай алах,
- 1.7 хувь нь хүчиндэх,
- 2.6 хувь нь булаах,
- 2.6 хувь нь дээрэмдэх,
- 3.4 хувь нь залилан мэхлэх,
- 6.8 хувь нь танхайрах,
- 12.8 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 58.9 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 9.5 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.

---ooOoo---

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Монгол Улсад 2013 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Иргэдээс цагдаагийн байгууллагад хандаж 2013 онд гэмт хэрэг, зөрчлийн талаарх 174079 гомдол, мэдээлэл ирүүлсэн нь өмнөх оныхоос 23.2 хувиар өсчээ.

Гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл нь нийгэмд гарч буй гэмт явдал, ажилгүйдэл, архидалт, ядуурал, хүн амын орлого, амьжиргааны түвшин, шилжилт хөдөлгөөн, төвлөрлөөс үүдэлтэй сөрөг үр дагавар, хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт, зарим иргэдийн ухамсар, ёс зүй, төлөвшил, хүмүүжил, эрх зүйн зүйн мэдлэг зэрэг нийгэм, эдийн засгийн шинжтэй олон хүчин зүйлстэй холбоотой байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээгээ иргэд олон нийтэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгаа нь гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажлын ачаалалд нөлөөлж байна.

2. Улсын хэмжээнд 2013 онд 25362 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 14.8 хувь, нийслэлийн хэмжээнд 15419 бүртгэгдсэн нь 19.4 хувиар тус тус өсчээ.

➢ Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн:
- 0.8 хувийг хүнийг санаатай алах,
- 0.9 хувийг булаах,
- 1.3 хувийг хүчиндэх,
- 1.3 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх,
- 2.4 хувийг дээрэмдэх,
- 4.8 хувийг залилан мэхлэх,
- 5.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 7.2 хувийг танхайрах,
- 29.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 31.1 хувийг хулгайлах,
- 14.8 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг өмнөх оныхоос өссөн ч бусдыг амиа хорлоход хүргэх, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, ойн тухай хууль тогтоомж зөрчих, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүнийг санаатай алах, татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох зэрэг хэргүүд буурсан үзүүлэлттэй байна.

Манай улсад бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаанаас үзэхэд ажилгүйдэл, архидалт, ядуурал, хүн амын шилжилт хөдөлгөөн, хүн амын амьжиргааны түвшингийн байдал, амар хялбар аргаар мөнгөжих, хөрөнгөжих гэсэн шунал сэтгэл зэрэг олон хүчин зүйлс гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөлүүд болж байна.

3. Гэмт хэргийн 58.4 хувь нь нийслэл хотод үйлдэгджээ. Энэ статистик үзүүлэлтээс дүгнэхэд хүн амын тоо гэмт хэргийн гаралтын байдалд нөлөөлж буйг харуулж байна.

➢Нийслэл хотод бүртгэгдсэн нийт 15419 гэмт хэргийн:

- 24.3 хувь нь Баянзүрх,
- 18.0 хувь нь Сонгинохайрхан,
- 16.3 хувь нь Баянгол,
- 15.7 хувь нь Сүхбаатар,
- 13.7 хувь нь Чингэлтэй,
- 8.0 хувь нь Хан-Уул,
- 2.0 хувь нь Налайх
- 1.8 хувь нь Багануур,
- 0.2 хувь нь Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт тус тус үйлдэгдсэн байна.

➢Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн:

- 38.4 хувь нь аймгуудад,
- 0.3 хувь нь төмөр замын салбарт,
- 0.3 хувь нь иргэний агаарын тээврийн салбарт,
- 0.1 хувь нь бусад газарт тус тус бүртгэгджээ.

Төр, засаг болон нутгийн захиргааны байгууллагаас нийслэл болон зарим аймгуудын нутаг дэвсгэрт хөдөлгөөнт эргүүл, камерын хяналтын системийг нэвтрүүлэх, автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа нь гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг шуурхай олж тогтоох ажилд үр дүнгээ өгч байна.

Нийслэл Улаанбаатар хотын эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд цагдаагийн байгууллагын хяналтыг өргөжүүлэх нь улсын хэмжээний нөхцөл байдалд үр дүнгээ өгнө гэж үзэж байна.

4. 2013 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 10910 гэмт хэрэг бүртгэгдсэний 58.5 хувийн гэмт этгээдийг олж илрүүлсэн нь өмнөх оныхоос 2.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 4.8 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 4.8 хувиартус тус өссөн байна.

5. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэргийн илрүүлэлт 2013 оны байдлаар улсын дундаж үзүүлэлтээс доогуур байгаа Завхан, Увс, Говьсүмбэр, Дундговь, Дархан-Уул, Төв, Булган, Дорнод, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтсүүд үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт хийж, илрүүлэлтийг ахиулах ажлын хүрээнд төрөл мэргэжлийн албад, алба хаагчдын хүчийг оновчтой зохион байгуулж, жигд ажиллагааг нь хангаж ажиллах шаардлагатай байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 91.3 хувийг хөнгөн, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг эзэлж байхад илрүүлэлт нь дунджаар 57.4 хувьтай байгаад төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн удирдлага анхаарч, дээрх ангиллын гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулахад удирдлагын зохион байгуулалт хяналтын үр нөлөөг дээшлүүлэх нь чухал байна.

6. Статистик үзүүлэлтээр улсын хэмжээнд бүртгэгдэж байгаа нийт гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн эзлэх жин зонхилох хувийг эзэлж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хохирлын хэмжээ төдийлөн буурахгүй, өсөх хандлагатай байна. Тухайлбал:

Д/д	Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013
1	Бүртгэгдсэн нийт хэрэг	20373	19825	19197	22089	25362
2	Үүнээс: хулгайлах хэрэг	6376	5777	5276	6266	7884
3	Нийт хэрэгт эзлэх жин	31.2	29.1	27.5	28.4	31.1
4	Нийт хэрэгт эзлэх жингийн өсөлт, бууралт	+15.3	-2.1	-1.6	+0.9	+0.9

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн төрөл мэргэжлийн албадын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулж, урьд үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хүнд, онц хүнд, их хэмжээний хохиролтой хэргүүдийн эзэн холбогдогчийг олж тогтоох, гэмт үйлдлийг нь таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүргэхэд цагдаагийн шат шатны байгууллага, алба хаагч бүрийн анхаарал, ажлын оновчтой зохион байгуулалт чухал байна.

7. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт 22286 хүн холбогдон шалгагдсаны:
   - 50.7 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй,
   - 25.5 хувь нь гэмт хэргийг согтуугаар үйлдсэн,
   - 18.3 хувь нь гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэсэн,
   - 4.1 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс тус тус эзэлж байна.

➢Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн:
   - 2 хүн тутмын нэг нь эрхэлсэн тодорхой ажилгүй,
   - 4 хүн тутмын нэг нь гэмт хэргийг согтуугаар үйлдсэн,
   - 24 хүн тутмын нэг нь урьд ял шийтгэгдэж байсан хүмүүс эзэлж байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 2014 оны 01 дүгээр сард гаргасан мэдээгээр манай улсад албан ёсоор бүртгэлтэй эрхэлсэн ажилгүй иргэдийн тоо 42.8 мянга болж, өмнөх оныхоос 19.6 хувь өссөн байна. Бүртгэлтэй эрхэлсэн ажилгүй иргэдийн 23.8 мянга буюу 54.9 хувийг эмэгтэй, 5.7 мянга буюу 13.3 хувийг 15-34 насны хүмүүс байна.

Статистик мэдээний дээрх үзүүлэлтүүд нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд архидалт, ажилгүйдэл, ядуурлын түвшин нөлөөлж байгааг харуулж байна.

8. Зах зээлд нийлүүлэгдэж буй архи, согтууруулах ундааны хэмжээ, түүний хэрэглээ нэмэгдэж, архидан согтуурах явдал нийгмийн түгээмэл үзэгдэл болсон нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэгдэх суурь шалтгаан, нөхцөл болж байна.

Хүн амын төвлөрөл, ажилгүйдэл, ядуурал, хүмүүсийн төлөвшил, хүмүүжил, ёс суртахуун, гэр бүлийн орчин, найз нөхдийн харилцаа зэргээс шалтгаалан архидан согтуурах явдал нийгэмд газар авч, архины хэрэглээ, түүнээс улбаалан гарах сөрөг үр дагавар, хор уршиг жил ирэх тутам нэмэгдэх хандлагатай байна.

Тухайлбал бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 27.2 хувь,

- хүнийг санаатай алах гэмт хэргийн 2.2 хувь,
- бусдын биемахбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 51.2 хувь,
- хүчиндэх гэмт хэгийн 2.7 хувь,
- хулгайлах гэмт хэргийн 11.3 хувь,
- булаах гэмт хэргийн 0.5 хувь,
- дээрэмдэх гэмт хэргийн 2.8 хувь нь,
- залилан мэхлэх гэмт хэргийн 0.2 хувь,
- завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 0.07 хувь нь,
- танхайрах гэмт хэргийн 0.5 хувь нь,
- тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 4.9 хувь нь тус тус согтуугаар үйлдэгдсэн байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй болсон, гэмт хэрэг, зөрчил гаргасны улмаас 123454 хүн эрүүлжүүлсэн нь өмнөх оныхоос 4.6 хувиар өссөн байна.

➢Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн:

- 51.7 хувь нь нийслэлд,
- 45.1 хувь нь аймгуудад байна.

Тэдгээрийн:

- 80632 буюу 65.3 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан,
- 15293 буюу 12.4 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон,
- 8160 буюу 6.6 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас биеэ авч явах чадваргүй болсон,
- 12769 буюу 10.3 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон,
- 4995 буюу 4.0 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй,
- 1605 буюу 1.3 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй байсаны улмаас тус тус эрүүлжүүлэгджээ.

Цаашид архидан согтуурах явдалтай тэмцэх ажлын хүрээнд архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын хэмжээ, худалдаж борлуулдаг, үйлчилдэг газар, цэгүүдийн тоог зохистой түвшинд хүртэл бууруулах, архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхийн хор уршгийг иргэд олон нийтэд ойлгуулан ухамсарлуулах, энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг үр нөлөө өгөхүйц хэмжээнд зохион байгуулах хэрэгтэй байна.

9. Гадаадын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй гарч байна.

➢Манай улсын нутаг дэвсгэрт 2013 оны байдлаар 75 эрүүгийн хэрэгт гадаадын 79 иргэн холбогдон шалгагдсаны:

- БНХАУ-ын 41,
- ОХУ-ын 12,
- БНСУ-ын 8,
- Франц, Вьетнам улсын тус бүр 3,
- Бангладеш, Япон, Австрали улсын тус бүр 2,
- Белорус, Мексик, Филиппин, Польш, Сири, Их Британи Умард Ирландын Вант улсын тус бүр 1 иргэн байна.

Иймд төрийн эрх бүхий шат шатны байгууллагуудын зүгээс гадаадын байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд тавих хяналт, бүртгэл судалгааг тогтмолжуулах шаардлагатай байна.

10. Гэмт хэргийн улмаас нийгэм, ард иргэдэд учирч буй хор хохирол жилээс жилд нэмэгдэж байна.

➢Гэмт хэргийн халдлагад:
- 25015 иргэн,
- 157 байгууллага, аж ахуйн нэгж өртөж,
- гэмт хэргийн улмаас 159024.2 тэрбум төгрөгний хохирол учирсан,
- энэ нь өмнөх оныхоос 3.0 дахин өссөн байна.

Гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх ашиг нь зөрчигдөж хохирсон иргэн нь гэмт этгээдэд хариуцлага тооцуулах асуудлаас илүүтэй өөрт учирсан хохирлыг нөхөн барагдуулах сонирхолтой байна.

Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирлыг төлүүлэх, нэхэмжлэлийг бүрэн хангах боломжтой байцаан шийтгэх ажиллагааны бүхий л ажиллагааг шуурхай, бүрэн явуулж байх шаардлагатай байна.

➢Гэмт хэргийн улмаас:
- 949 хүн нас барж,
- 9797 хүн гэмтсэн,
- өмнөх оныхоос нас барсан хүний тоо 5.3 хувиар өсч,
- гэмтсэн хүний тоо16.1 хувиар өссөн байх ба цаашид хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох ажиллагааг эрчимжүүлж ажиллах хэрэгтэй байна.

11. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2013 онд 777793 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2.3 хувиар буурсан.

➢Зөрчил гаргасан 726716 иргэн,
- 52 албан тушаалтан,
- 1212 аж ахуйн нэгж, байгууллагыг 4.8 тэрбум төгрөгөөр тус тус торгож,
- 33308 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах,
- 16505 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

➢Үйлдэгдсэн бүх зөрчлийн:
- 40.5 хувь нь Замын цагдаагийн газрын хариуцсан чиг үүрэгт хамаарах салбарт,
- 32.6 хувь нь аймгуудад,
- 24.3 хувь нь нийслэлийн дүүргүүдэд,
- 2.1 хувь нь төмөр замын салбарт,
- 2.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгох, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор батлсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цагдаагийн шат шатны байгууллага санал, санаачилгатай ажиллах нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд үр дүн өгнө гэж үзэж байна.

ГУРАВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТӨВ, ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,
мэдээлэл, судалгааны ажлын чиглэлээр

Монгол Улсад 2013 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ болон цагдаагийн байгууллагын мэдээлэл, судалгааны ажилтай холбоотой тушаал, журам, зааврын хэрэгжилтийн байдалд судалгаа, шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр төв, орон нутгийн цагдаагийн байгууллагуудын үйл ажиллагаанд зориулж дараах зөвлөмжийг бэлтгэлээ. Үүнд:

1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 7884 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 1618 хэргээр буюу 25.8 хувийг эзэлж, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 31.1 хувийг эзэлсэн. Бүртгэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах нийт гэмт хэргийн 32.6 хувь нь “Даваа”, “Мягмар” гаригуудад, 47.3 хувь нь 22.00-06.00 цагт үйлдэгдсэн, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон шалгагдсан нийт 5386 хүний 53.0 хувь нь 18-29 насны хүмүүс байгаа статистик судалгаа гарч байна.

<u>Статистик мэдээнд дүгнэлт хийж</u>:

- тус тусын нутаг дэвсгэрт 2013 онд үйлдэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн үйлдэгдсэн сар, өдөр, цаг хугацаа, газар, холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн онцлог, урьд гэмт хэрэгт холбогдож байсан байдал, хулгайлагдсан эд зүйлсийн төрөл зэрэгт судалгаа хийж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж, цагдаагийн ажил, чиг үүргийг хэрэгжүүлэх;
- аймаг, нийслэл, сум, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хариуцсан нутаг дэвсгэр дэх бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар зөвлөлөөс хийх ажлын саналын талаар танилцуулж холбогдох ажлыг зохион байгуулуулах;
- хариуцсан нутаг дэвсгэр, обьектод үйл ажиллагаа явуулж буй бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн халдлагад өртөж болзошгүй аж хуйн нэгж, байгууллагуудад орчныхоо гэрэлтүүлгийг сайжруулах, харуул, жижүүрийнхээ сонор сэрэмжийг дээшлүүлэх, телекамерын хяналтын системийг ашиглах чиглэлээр зөвлөмж өгөх;
- хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглан иргэд олон нийтэд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн халдлагаас урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байх.

2. Сүүлийн үед гэр бүлийн хүчирхийллийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд хохирох, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхтэй холбоотой гэмт хэргүүд нийгмийг эмзэглүүлж байна.

2013 оны статистик мэдээгээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 418 гэмт хэрэг бүртгэгдэж, түүний улмаас 419 хүн хохирч, 7 хүн нас барж, 319 гэмтсэн байх ба хохирсон нийт хүмүүсийн 92.6 хувь нь эмэгтэй, 6.0 хувь нь хүүхэд тус тус байна.

“Ахуйн шинжтэй” гэдгээр гомдол, мэдээлэл гардаггүй, гаргасан нь гомдлоо буцаан авснаар шалгагдалгүй орхигддог, эсхүл гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, хохирогч нь эвлэрсэн гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болж шийдвэрлэгдэж буй гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг цөөнгүй байгаад анхаарах шаардлага гарч байна.

<u>Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд</u>:

- “Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар” /Код 702/-т заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч” гэсэн судалгааг бүрдүүлэх чиг үүрэг бүхий ажлын байр /албан тушаал/-нд ажиллаж байгаа алба хаагчдаар дээрхи судалгаагаар мэдээллийн санг бүрдүүлж байхад удирдлага, зохион байгуулалтыг чиглүүлж, санг урьдчилан сэргийлэх ажилд тогтмол ашиглах;

- гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, үйлдэж болзошгүй, үйлдэж хариуцлага тооцогдож байсан хүмүүсийн судалгааг гаргаж, тэдгээртэй нэгбүрчлэн уулзаж гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэн сэргийлэх ажлыг зохион байгуулж байх;

- гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сэргийлэх ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгийг авч хамтран ажиллаж байх;

- гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд судалгаа явуулахдаа тухайн айл өрхийн гишүүдийн хувийн нууц, нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандаж байх.

3. 2013 онд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйл/ 1419 бүртгэгдсэний 51.4 хувь нь аймаг орон нутагт гарсан байх ба энэ гэмт хэргийн улмаас 417 хүн нас барж, 967 хүн гэмтсэнээс нас барсан хүний 71.9, гэмтсэн хүний 51.4 хувь нь орон нутагт гарсан гэмт хэрэгтэй холбоотой байна.

<u>Дээрхи статистик мэдээнд дүгнэлт хийж орон нутагт</u>:

- хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түүнээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулж байх;

- улсын чанартай болон хөдөлгөөний нягтаршил ихтэй замуудад хөдөлгөөнт хяналт тавьж байх;

- суурин хяналтын цэгүүдийг байгуулж ажиллуулах талаар нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг авч хэрэгжүүлэх;

- замын хөдөлгөөний дүрмийг сурталчилах, хэрэгжүүлэх талаар иргэдийн дунд уулзалт, ярилцлага хийж байх;

- замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөнөөс үүдэн гарч байгаа гэмт хэрэг, захиргааны зөрчил, түүний шалтгаан, нөхцөл, хор уршигийн талаар талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл өгч байх;

- жолооч бэлтгэж байгаа сургалтанд тавих хяналтыг чанаржуулах;

- согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлгэ тогтмол явуулж байх, түүнтэй холбоотой сэрэмжлүүлэх, анхааруулах самбарыг орон нутгийн замд байршуулж ажиллуулах.

4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2013 онд 6406 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 40.9 хувиар өссөн байх ба 5695 хүн согтуугаар гэмт хэрэг үйлдэж шалгагдсаны 49.5 хувь нь 18-29 насны, 5.9 хувь нь эмэгтэй, 1.9 хувь нь16 хүртэл насны хүн байна.

Монгол Улсад бүртгэгдсэн 4 хэрэг тутмын нэг нь согтуугаар үйлдэгдсэн байх ба согтуугаар үйлдэгдсэн нийт хэргийн 51.2 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 16.9 хувийг танхайрах, 11.3 хувийг хулгайлах, 4.6 хувийг тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 2.8 хувийг дээрэмдэх, 2.7 хувийг хүчиндэх, 2.2 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг тус тус эзэлж, 47.4 хувь нь 22.00-06.00 цагт, 79.3 хувь нь гэр, орон сууц, гудамж, талбай, олон нийтийн газарт тус тус үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас 5602 иргэн хохирсоноос 263 хүн нас барж, 3809 хүн гэмтэж, 4.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Дээрхи статистик мэдээ нь архидан согтуурах явдал нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үүдэн гарах үндсэн шалтгаан, нөхцөлийн нэг байсаар байгааг нотолж байна.

Архидан согтуурах явдалтай тэмцэх, түүнээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

- согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил, түүнээс учирсан хор хохирол, сөрөг үр дагаврын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглан иргэдэд мэдээлэл, сэрэмжлүүлэг өгч, уулзалт, ярилцлага хийж байх;
- согтууруулах ундааг байнга, хэтрүүлэн хэрэглэдэг, орчиндоо айдас түгшүүр төрүүлдэг, гэмт хэрэг, зөрчил гаргаж болзошгүй эрсдэл бүхий этгээдэд тавих цагдаагийн ажил, үйлчилгээний хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх ажил зохиох;
- согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ захиргааны зөрчил гаргасан тохиолдолд бүрт хууль тогтоомжид заасан албадлагын арга хэмжээ авч, хариуцлага тооцож байх;
- согтууруулах ундаагаар үйлчилдэг, гэмт хэрэг, хэрэг зөрчил ихээр гардаг цэгүүдэд цагдаагийн эргүүл, шалтгалтыг тогтмолжуулж, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх;
- архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулах ажилд бусад төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхижүүлэх чиглэлээр санал, санаачилга гарган хамтран ажиллаж байх;
- архидан согтуурлаас үүдэн гарч болзошгүй хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд архидан согтуурлын эсрэг аяныг зохион байгуулж, иргэд олон нийтийг өргөнөөр татан оролцуулж байх.

5. Төр, засаг болон Цагдаагийн ерөнхий газраас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодлого тодорхойлж, түүнийг ажил, арга хэмжээ болгон хэрэгжүүлж зохион байгуулах, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт хийн цаашдын ажлын чиглэлийг тодорхойлоход цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, туслах тоо бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан нь нэн чухал ач холбогдолтой билээ.

Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн талаархи мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд цаг тухайд нь үнэн, зөв, бүрэн дүүрэн оруулж байх асуудал дээр зөрчил, дутагдал тасрахгүй гарсаар байгаад анхаарах шаардлагатай байгаа юм.

Үүнд дүгнэлт хийж:

- төв, орон нутгийн цагдаагийн шат шатны байгууллагын удирдлагууд “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар” /Код 701/, “Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар” /Код 702/-т заасны дагуу эдгээр зааврын хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэнд нь хяналт тавьж, зөрчил, дутгадлыг арилгуулах арга хэмжээ авч байх үүргийн биелэлтийг хангах;
- “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар” /Код 701/, “Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар” /Код 702/-аар улирал бүр нэгээс доошгүй удаа бие бүрэлдэхүүний дунд сургалт зохион байгуулах;
- цагдаагийн байгууллагын мэдээллийн санг бүрдүүлэхийн зэрэгцээ уг сангаас шаардлагатай мэдээллийг шуурхай авч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглах;
- цагдаагийн байгууллагын мэдээллийн санг бүрдүүлэх, түүнийг ашиглаж байх ажлыг тасралтгүй, шуурхай явуулж байхын тулд байгууллагын мэдээллийн технологийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, түүний хангалт, үйлчилгээнд анхаарах;

- алба хаагч бүр цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээний орчинд ажиллах чадвар эзэмшсэн эсэх үр дүнг тооцож, шаардлагатай алба хаагчдад сургалт зохион байгуулж ур чадварыг эзэмшүүлэх;

- гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл бүрийг шалгах ажиллагааны явцад холбогдох маягтуудын дагуу мэдээллийг "цаг хугацаанд нь, үнэн зөв, бүрэн гүйцэд" санд оруулж хэвших.

6. Хариуцсан нутаг дэвсгэр, обьектод үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн байгууллагаас явуулах үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах ажлыг дэмжих зорилготой төв, орон нутгийн цагдаагийн байгууллагууд дахь судалгаа, дүн шинжилгээний багийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 229 дүгээр тушаалаар баталсан.

Гэтэл судалгааны багийн хийх ажил нь тухайн байгууллагын ганц, хоёр хүний, тодруулбал мэдээлэл, судалгааны ажил хариуцсан алба хаагчийн ажил, үүрэг мэт байдлаар хэрэгжиж, удирдамжийн дагуу хэрэгжихгүй байгаа явдал гарч байна.

<u>Судалгааны багийн ажлын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд</u>:

- дээрхи тушаалаар баталсан удирдамжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах;

- судалгааны багийн гишүүн бүрийн ажил, үүргийн хуваарийг гаргаж, тэдгээрийн хийх ажлын үр дүнг тогтмол тооцож, ажлын хариуцлага, үр дүнг нь дээшлүүлэх;

- байгууллагын удирдлага бүр судалгааны ажилд биечлэн идэвх зүтгэл, санал, санаачилга гарган оролцож, удирдан зохион байгуулж байх.

7. Мэдээлэл, судалгааны төв нь сар, жил бүр Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн талаархи 2 төрлийн статистик мэдээ гаргаж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд байршуулж байгаа.

Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагуудын үйл ажиллагаанаас үзэхэд статистик мэдээг байгууллагууд нь ажлын тайлан, дүн мэдээ гаргах ажилдаа түлхүү ашиглаж, харин түүнд дүн шинжилгээ, судалгаа хийж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглаж байх явдал тогтмолжихгүй байна.

<u>Цаашид үйл ажиллагаандаа</u>:

- дээрхи 2 төрлийн статистик мэдээг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглаж байх;
- статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, ирж буй цаг хугацааны үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлаа урьдчилан төлөвлөж хэрэгжүүлж байх;
- статистик мэдээнд судалгаа, шинжилгээ хийж, аль саруудад ямар төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүний улмаас учирсан хор уршиг нэмэгддэг судалгааг урьдчилан гаргаж, урьдчилан сэргийлэх ажлыг тухайн цаг үеийн эрүү, хэв журмын давтамжид нөхцөл байдалд уялдуулан явуулж байх.

8. <u>Бусад үйл ажиллагааны чиглэлээр:</u>

- гудамж, талбайд тогтмол эргүүл ажиллуулах нь тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлаганд түргэн шуурхай очих, улмаар гэмт үйлдлийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөн хөөж баривчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг халуун мөрөөр нь олж илрүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй сэжигтэй этгээд болон гудамж талбайг хяналтандаа авах зэрэгт ач холбогдолтойг анхаарч, эргүүлийн ажлын менежментэнд удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх;

- эргүүлийн чиглэлийг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, дуудлага, мэдээлэл байнга ирдэг цэг, газар, алслагдсан суурин газарт ажиллуулах;
- цаашид гудамж, талбай, олон нийтийн газруудыг хяналтанд авах ажлыг зөвхөн цагдаагийн эргүүлээр хязгаарлахгүйгээр тэдгээрийг камержуулан хянаж байх, түүнчлэн гэрэлтүүлэгтэй болгож гэмт үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх нөхцөл орчинг бий болгох чиглэлээр нутгийн төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн байгууллагын хэмжээнд болон өөрийн хариуцсан нутаг, дэвсгэр, обьектын хүрээнд бус, зэргэлдээ оршиж байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болон хууль сахиулах бусад байгууллагатай харилцан мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах чиглэлээр зохион байгуулж байх;
- цагдаагийн ажил албанд шинээр томилогдсон алба хаагчийг хүлээн авсан тухайн байгууллага түүнийг ажлын байранд нь дадлагажуулан сургах үйл ажиллагаа дутмаг хийгдэж байгаа нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэнд нөлөө үзүүлж байгаа тул ажлын дадлага, туршлага суулгах сургалтыг үр өгөөжтэй зохион байгуулж байх.

Дээрх зөвлөмжүүд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд тань дэмжлэг, үр нөлөө өгнө гэдэгт найдаж байна.

Танай байгууллага, хамт олонд ажлын амжилт бүтээлийг хүсье.

МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨВ